

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/173/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Одгэрэл

Утас: 70453721, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

НАРАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
П.НАРАН-ЭРДЭНЭ ТАНАА

2022.09.25 № УВА-2022/173/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200100046

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>32,514,236.72</b>	<b>78,820,788.05</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	10,476,639.32
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	10,476,639.32
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	10,476,639.32
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,181,695.07
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	8,294,944.25
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	16,452,377.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	15,641,300.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	811,077.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	811,077.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	32,514,236.72	51,891,771.73
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,064,005.99	701,520.00
35130	Эм боох материал	5,064,005.99	701,520.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	26,650,230.73	50,390,251.73
35410	Бичиг хэргийн материал	1,290,198.00	1,881,498.00
35420	Аж ахуйн материал	19,424,556.00	39,451,520.53
35450	Барилгын засварын материал	1,076,750.00	1,076,750.00
35460	Хүнсний материал	1,297,846.73	3,085,303.20
35470	Бусад хангамжийн материал	3,560,880.00	4,895,180.00
35600	Мал амьтад	800,000.00	800,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>502,031,162.03</b>	<b>662,448,487.56</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	502,031,162.03	662,448,487.56
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	492,315,762.03	652,733,087.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	414,814,746.00	414,814,746.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19,258,753.48	-26,754,850.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,620,000.00	141,730,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-45,008,423.83	-46,296,090.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,115,682.00	230,149,582.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-58,903,733.76	-69,021,564.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,907,832.00	18,907,832.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,971,586.90	-10,796,566.90
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,715,400.00	9,715,400.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,715,400.00	9,715,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>534,545,398.75</b>	<b>741,269,275.61</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,388,428.00</b>	<b>433,859.07</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	10,388,428.00	433,859.07
<b>413</b>	<b>Өглөг</b>	10,388,428.00	433,859.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	433,859.07
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	10,388,428.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,388,428.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>524,156,970.75</b>	<b>740,835,416.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	524,156,970.75	740,835,416.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	650,238,510.00	650,238,510.00
51101	Өмч: - төрийн	650,238,510.00	650,238,510.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-204,785,613.67	11,892,832.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-204,785,613.67	-204,785,613.67
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	216,678,445.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,704,074.42	78,704,074.42
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>534,545,398.75</b>	<b>741,269,275.61</b>

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>499,380,110.00</b>	<b>825,949,240.09</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>47,900,000.00</b>	<b>204,422,560.09</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	47,900,000.00	204,422,560.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,900,000.00	204,422,560.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,900,000.00	204,422,560.09
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>65,557,010.00</b>	<b>172,513,480.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,923,100.00	449,013,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,394,200.00	96,904,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,394,200.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	96,904,340.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,024,700.00	42,971,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,024,700.00	42,971,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	18,138,110.00	32,638,140.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,138,110.00	32,638,140.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>483,559,473.60</b>	<b>609,270,794.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>483,559,473.60</b>	<b>609,270,794.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	475,929,532.60	574,722,459.65
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	310,993,520.00	363,136,007.27
210101	Үндсэн цалин	280,135,300.00	363,136,007.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,814,028.00	00.00
210104	Урамшуулал	20,008,392.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,035,800.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,719,659.00	46,857,724.49
210201	Тэтгэврийн даатгал	26,228,300.00	33,064,141.46
210202	Тэтгэмжийн даатгал	3,090,397.00	3,482,448.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,516,708.00	2,765,800.12
210204	Ажилгүйдлийн даатгал	665,874.00	685,939.52
210205	Эрүүл мэндийн даатгал	6,218,380.00	6,859,394.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,179,948.00	29,010,860.35
210301	Гэрэл, цахилгаан	1,982,408.00	2,659,365.35
210302	Түлш, халаалт	33,994,928.00	26,351,495.00
210303	Цэвэр, бохир ус	202,612.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,021,217.00	26,300,200.00
210401	Бичиг хэрэг	3,830,507.00	1,566,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,001,040.00	19,320,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,453,000.00	879,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	96,000.00

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,553,200.00	2,901,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,183,470.00	1,537,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,932,842.00</b>	<b>68,412,198.52</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,116,930.00	57,728,143.39
210502	Хоол, хүнс	8,761,412.00	7,813,055.13
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,054,500.00	2,871,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,969,174.00</b>	<b>3,715,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,834,308.00	00.00
210602	Тавилга	1,442,036.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	980,500.00	1,435,000.00
210604	Урсгал засвар	3,712,330.00	2,280,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>424,000.00</b>	<b>396,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	424,000.00	396,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>915,310.00</b>	<b>1,040,845.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,400.00	288,864.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,510.00	104,010.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	220,000.00
210807	Газрын төлбөр	63,000.00	58,296.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,773,862.60</b>	<b>35,852,824.03</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,732,900.00	1,025,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,040,962.60	34,827,824.03
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,629,941.00</b>	<b>34,548,334.65</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>34,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	34,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,629,941.00</b>	<b>548,334.65</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,629,941.00	548,334.65
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>15,820,636.40</u></b>	<b><u>216,678,445.79</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>15,820,636.40</u></b>	<b><u>216,678,445.79</u></b>

### 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>451,480,110.00</b>	<b>605,885,380.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>451,480,110.00</b>	<b>605,885,380.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,923,100.00	449,013,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,394,200.00	96,904,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,394,200.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	96,904,340.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,024,700.00	42,971,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,024,700.00	42,971,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	18,138,110.00	16,996,840.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,138,110.00	16,996,840.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>447,775,110.00</b>	<b>589,003,540.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>447,775,110.00</b>	<b>589,003,540.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>440,145,169.00</b>	<b>554,455,206.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	310,436,367.00	362,485,366.60
210101	Үндсэн цалин	279,578,147.00	321,962,081.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,814,028.00	4,921,999.80
210104	Урамшуулал	20,008,392.00	31,031,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,035,800.00	4,570,085.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,276,812.00	47,074,506.08
210201	Тэтгэврийн даатгал	27,063,712.00	33,365,416.21
210202	Тэтгэмжийн даатгал	3,053,300.00	3,418,549.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,443,060.00	2,749,484.34
210204	Ажилгүйдлийн даатгал	610,240.00	684,523.30
210205	Эрүүл мэндийн даатгал	6,106,500.00	6,856,532.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,874,520.00	39,979,365.35
210301	Гэрэл, цахилгаан	1,982,408.00	2,428,365.35
210302	Түлш, халаалт	23,606,500.00	37,551,000.00
210303	Цэвэр, бохир ус	285,612.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,629,040.00	28,166,200.00
210401	Бичиг хэрэг	2,097,600.00	2,100,100.00
210402	Тээвэр, шатахуун	15,001,040.00	19,320,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,000.00	1,150,000.00
210404	Ном, хэвлэл	90,400.00	96,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	2,700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	2,800,000.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	37,958,640.00	68,169,323.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,574,000.00	53,049,323.00
210502	Хоол, хүнс	8,498,640.00	9,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,886,000.00	5,620,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,891,580.00	4,553,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	71,400.00	1,410,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	670,000.00	700,000.00
210604	Урсгал засвар	2,150,180.00	2,443,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	424,000.00	396,000.00
210702	Дотоод албан томилолт	424,000.00	396,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	915,310.00	1,271,845.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,400.00	288,864.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,510.00	55,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	48,910.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	451,000.00
210807	Газрын төлбөр	63,000.00	58,296.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,738,900.00	2,359,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,738,900.00	2,359,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,629,941.00</b>	<b>34,548,334.65</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	34,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	34,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	7,629,941.00	548,334.65
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	6,280,384.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,349,557.00	548,334.65
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3,705,000.00</b>	<b>16,881,839.32</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,705,000.00</b>	<b>6,405,200.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,705,000.00</b>	<b>6,405,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3,705,000.00	6,405,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,705,000.00	6,405,200.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-3,705,000.00</b>	<b>-6,405,200.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	10,476,639.32
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	10,476,639.32

**2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>650,238,510.00</b>	<b>78,704,074.42</b>	<b>-204,785,613.67</b>	524,156,970.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>650,238,510.00</b>	<b>78,704,074.42</b>	<b>-204,785,613.67</b>	524,156,970.75
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>650,238,510.00</b>	<b>78,704,074.42</b>	<b>-204,785,613.67</b>	524,156,970.75
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>650,238,510.00</b>	<b>78,704,074.42</b>	<b>-204,785,613.67</b>	524,156,970.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>650,238,510.00</b>	<b>78,704,074.42</b>	<b>-204,785,613.67</b>	524,156,970.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	216,678,445.79	216,678,445.79
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>650,238,510.00</b>	<b>78,704,074.42</b>	<b>11,892,832.12</b>	740,835,416.54

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	510,529,200.00	506,251,010.28	4,278,189.72	99.16
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	510,529,200.00	506,251,010.28	4,278,189.72	99.16
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	510,529,200.00	506,251,010.28	4,278,189.72	99.16
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	341,012,200.00	339,278,546.60	1,733,653.40	99.49
210101	Үндсэн цалин	298,341,000.00	298,755,261.80	-414,261.80	100.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	4,921,999.80	1,678,000.20	74.58
210104	Урамшуулал	31,031,200.00	31,031,200.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,570,085.00	469,915.00	90.68
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,036,600.00	45,075,953.33	960,646.67	97.91
210201	Тэтгэврийн даатгал	32,396,200.00	31,366,863.46	1,029,336.54	96.82
210202	Тэтгэмжийн даатгал	3,410,100.00	3,418,549.47	-8,449.47	100.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,728,100.00	2,749,484.34	-21,384.34	100.78
210204	Ажилгүйдлийн даатгал	682,000.00	684,523.30	-2,523.30	100.37
210205	Эрүүл мэндийн даатгал	6,820,200.00	6,856,532.76	-36,332.76	100.53
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,471,000.00	39,979,365.35	491,634.65	98.79
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,428,365.35	571,634.65	80.95
210302	Түлш, халаалт	36,921,000.00	37,551,000.00	-630,000.00	101.71
210303	Цэвэр, бохир ус	550,000.00	00.00	550,000.00	0.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,110,800.00	28,106,800.00	4,000.00	99.99
210401	Бичиг хэрэг	2,100,100.00	2,100,100.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	19,260,700.00	19,260,700.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,150,000.00	1,150,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	96,000.00	4,000.00	96.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	2,700,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,800,000.00	0.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	42,379,900.00	42,379,900.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,179,900.00	29,179,900.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	9,500,000.00	9,500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,700,000.00	3,700,000.00	0.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,460,000.00	7,403,300.00	56,700.00	99.24

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	4,260,000.00	4,260,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	700,000.00	700,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,443,300.00	56,700.00	97.73
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,150,000.00</b>	<b>396,000.00</b>	<b>754,000.00</b>	<b>34.43</b>
210702	Дотоод албан томилолт	1,150,000.00	396,000.00	754,000.00	34.43
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,408,700.00</b>	<b>1,271,845.00</b>	<b>136,855.00</b>	<b>90.29</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	288,864.00	11,136.00	96.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	288,000.00	72,000.00	80.00
210803	Даатгалын үйлчилгээ	110,600.00	81,675.00	28,925.00	73.85
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,100.00	55,100.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	48,910.00	6,090.00	88.93
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	451,000.00	14,000.00	96.99
210807	Газрын төлбөр	63,000.00	58,296.00	4,704.00	92.53
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,359,300.00</b>	<b>140,700.00</b>	<b>94.37</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,359,300.00	140,700.00	94.37
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>510,529,200.00</b>	<b>508,432,705.35</b>	<b>2,096,494.65</b>	<b>99.59</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>449,013,200.00</b>	<b>449,013,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	449,313,200.00	449,013,200.00	300,000.00	99.93
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>42,971,000.00</b>	<b>42,422,665.35</b>	<b>548,334.65</b>	<b>98.72</b>
132001	Орон нутгийн төсвөөс	42,971,000.00	42,422,665.35	548,334.65	98.72
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>18,545,000.00</b>	<b>16,996,840.00</b>	<b>1,548,160.00</b>	<b>91.65</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,545,000.00	16,996,840.00	1,548,160.00	91.65
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>0.00</b>	<b>.</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>2,181,695.07</b>	<b>-2,181,695.07</b>	

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>88,609,395.75</b>	<b>-88,609,395.75</b>	
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>88,609,395.75</b>	<b>-88,609,395.75</b>	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		54,609,395.75	<b>-54,609,395.75</b>	
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		23,206,820.00	<b>-23,206,820.00</b>	
210101	Үндсэн цалин		23,206,820.00	<b>-23,206,820.00</b>	
210102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		1,998,552.75	<b>-1,998,552.75</b>	
2102	Тэтгэврийн даатгал		1,998,552.75	<b>-1,998,552.75</b>	
210201	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		59,400.00	<b>-59,400.00</b>	
2104	Тээвэр, шатахуун		59,400.00	<b>-59,400.00</b>	
210401	<b>Нормативт зардал</b>		25,789,423.00	<b>-25,789,423.00</b>	
210402	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		23,869,423.00	<b>-23,869,423.00</b>	
210406	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,920,000.00	<b>-1,920,000.00</b>	
2105	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		3,555,200.00	<b>-3,555,200.00</b>	
210501	Багаж, техник, хэрэгсэл		3,555,200.00	<b>-3,555,200.00</b>	
210502	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		34,000,000.00	<b>-34,000,000.00</b>	
2109	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		34,000,000.00	<b>-34,000,000.00</b>	
210901	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		34,000,000.00	<b>-34,000,000.00</b>	
213	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		96,904,340.00	<b>-96,904,340.00</b>	
2132	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		96,904,340.00	<b>-96,904,340.00</b>	
213209	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		96,904,340.00	<b>-96,904,340.00</b>	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн нотолгоонд суурилсан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амд нээлттэй тэгш хүртээмжтэй үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 483,591.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,868.7 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 609,270.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,092.7 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 4,874.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 206,723.9 мянган төгрөгөөр буюу 38.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	10,476.6	10,476.6
Авлага	0.0	16,452.4	16,452.4
Бараа материал	32,514.2	51,891.8	19,377.6
Үндсэн хөрөнгө	502,031.0	662,448.5	160,417.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>534,545.4</b>	<b>741,269.3</b>	<b>206,723.9</b>
Өр төлбөр	10,388.4	433.9	-9,954.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	524,157.0	740,835.4	216,678.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>534,545.4</b>	<b>741,269.3</b>	<b>206,723.9</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 10,476.6 мянган төгрөг болж 10,476.6 мянган төгрөгөөр өссөн нь үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 16,452.4 мянган төгрөг болж 16,452.4 мянган төгрөгөөр өссөн нь ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн даатгалын сангаас авах

санхүүжилт дутуу ирсэн, 811.1 мянган төгрөгийн түлш халаалтын зардал илүү шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 51,891.8 мянган төгрөг болж 19,377.6 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой аж ахуйн болон бусад хангамжийн материал зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 662,448.5 мянган төгрөг болж 160,417.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,405.2 мянган төгрөг, хандив болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 188,839.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд 34,827.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон, 13,101.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 433.9 мянган төгрөг болж 9,954.5 мянган төгрөгөөр буурсан нь түлш халаалтын өр төлбөр барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 740,835.4 мянган төгрөг болж 216,678.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 326,569.1 мянган төгрөгөөр буюу 65.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 125,711.3 мянган төгрөгөөр буюу 26.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин хөлс, тээвэр шатахууны зардал, эм, бараа үйлчилгээний бусад зардал байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор гарсан зардлууд нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 610,700.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 610,700.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 100,170.8 мянган төгрөгөөр бууруулж 510,529.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, урамшуулал, хангамж, бараа материалын зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 510,529.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 449,013.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 42,971.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18,545.0 мянган төгрөгийн Эрүүл мэндийн даатгалын санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 449,013.2 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 16,996.8 мянга, орон нутгийн төсвөөс 42,422.7 мянга, нийт 508,432.7 төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 506,251.0 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 548.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 506,251.0 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар 88,609.4 мянган төгрөгийн орлого орж 88,609.4 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 147, хугацаа хоцроосон 2, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Наранбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 15,641.3 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Түлш халаалтын зардлын 811.1 мянган төгрөгийг илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.
2. Ковид-19 цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй ирсэн 5,200.0 мянган төгрөгийн материал бүртгэлд тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулав.
3. Санхүүгийн тайланд 9,715.4 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө буюу газрыг биет хөрөнгөөр тайлагнасныг залруулав.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Наранбулаг сумын Эрүүл мэндийн төв	3	15,726.5	3	15,726.5	-	-	-	-	-	-
<b>ДҮН</b>		3	15,726.5	3	15,726.5						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр